БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

УС АШИГЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

БОАЖЯ-ны ГЗБУНБЗГ-ын Усны нөөцийн хэлтсийн мэргэжилтэн Ж.Отгонбаяр

Байгаль орчны үнэлгээ, аудитын эрх зүйн асуудал сэдэвт сургалт

2017 оны 09 дүгээр сарын 20


Улаанбаатар хот

Ус ашиглуулах дүгнэлт гаргах

- хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн усаар хангагч байгууллагад Байгаль орчин, аялал жуулчлалын яам
- хоногт 100 шоометрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг Монгол-Ус” ТӨҮГ
- хоногт 50-100 шоометр ус шиглуулах дүгнэлтийг Сав газрын захиргаа
- хоногт 50 шоометр хүртэлх ус ашиглуулах дүгнэлтийг аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал, жуулчлалын газар

Ус ашиглах зөвшөөрөл олгох

Ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн:



Хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн усаар хангагч байгууллага
Байгаль орчин, аялал жуулчлалын яамаар дүгнэлт гаргуулж,
сав газрын захиргаанаас ус ашиглах зөвшөөрөл авна.

Ус ашиглах гэрээ байгуулах

Ус ашиглах дүгнэлт,
зөвшөөрлийг зөвшөөрлийг үндэслэн:

хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрээс хангагдаж байгаа ус ашиглагчтай тухайн усаар хангагч байгууллага.

төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрээс хангагдаж байгаа ус ашиглагчтай:
- Сав газрын захиргаа;
- аймаг, нийслэлийн БОАЖГ;
- сум, дүүргийн Засаг дарга.

Ус ашиглах эрхийн бичиг олгох

Аймаг, нийслэлийн БОАЖГ

Сум, дүүргийн байгаль хамгаалагч

→ Ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрлийг үндэслэн ус ашиглах эрхийн бичиг олгох

Аймаг, нийслэлийн БОАЖГ-ын бүрэн эрх

усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, усан орчинг нөхөн сэргээх, ус хангамж, ариутгах татуургын болон хаягдал ус зайлуулах үйл ажиллагаанд хяналт тавих /Усны тухай хуулийн 18.1.3/

Сав газрын захиргааны бүрэн эрх

сав газрын хэмжээнд ашиглах боломжит усны нөөц, ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавьж ажиллах /Усны тухай хуулийн 17.1.10/

Ус, рашааны нөөц ашигласны төлбөр

Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ус, рашааны нөөц ашигласны төлбөр төлнө /Усны тухай хуулийн 31.1/

Ус, рашааны нөөц ашигласны төлбөр ногдох зүйл /Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 6.1.1-6.1.4/:
- хүн амын унд, ахуйн болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан ус;
- уул уурхайн үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан ус;
- эмчилгээ, сувилгаа, халаалт болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан рашаан;
- эрчим хүч үйлдвэрлэх, тээвэр хийх болон усны амьтан, ургамал өсгөн үржүүлэх зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан ус, рашааны орчин.

Төсвийн тухай хуулийн:
Аймаг, нийслэлийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ:
- үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр /хуулийн 23.6.5/;

Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ:
- хүн амын унд, ахуйн хэрэгцээний зориулалтаар ус, рашаан ашигласны төлбөр /хуулийн 23.8.9/

Усны нөөц ашигласны төлбөрийн төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13.5-д зааснаар Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам-ыг баталсан.

Төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх /журмын 2.1/

АНСДЗД нь тухайн жилийн байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төсвийн орлогыг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан хувь, хэмжээний доод хязгаар ... хэмжээгээр бүрдүүлэх саналыг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.

Тухайн жилийн төсвийн суурь зарлагын төлөвлөгөөнд тусгах арга хэмжээ:
- усны сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагын саналыг үндэслэн “Ус” үндэсний хөтөлбөр, усны нөөцийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ /журмын 2.2.3/

Төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалт

Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийг /журмын 3.2.1-3.2.5/:

• усны сав газарт усны нөөцийн хайгуул судалгаа, зураглал хийх, усны нөөц, горим, чанарын төлөв байдал, өөрчлөлтөд хяналт-шинжилгээ явуулах, усны тоо бүртгэл хийх;

• усны үр ашигтай, хэмнэлттэй хэрэглээг болон хаягдал усыг дэвшилтэт технологиор цэвэрлэх, тоолууржуулах, унд-ахуйн ус хангамж, ариутгах татуургын байгууламжийг шинэчлэх, засч сэлбэхийг дэмжих, ундны ус цэнгэгжүүлэх, усны хяналт шинжилгээний болон лабораторийн тоног төхөөрөмж худалдан авах, хаягдал ус зайлуулах цэгийг сайжруулах;

• Усны тухай хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, дүрэм журмыг мөрдүүлэх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн заагийг тэмдэгжүүлэх, хаалт, хамгаалалт хийх, тохижуулах;

• усны сав газрын усны нөөцийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, усны сав газрын зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих, орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх;

• усны сав газрын байгаль хамгаалал, нөхөн сэргээлт, цас, борооны усыг хуримтлуулах хөв цөөрөм байгуулах, рашаан, гол мөрний урсац бүрэлдэх эх, булаг шанд, баянбүрдийг хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээ

Төлбөрийн орлогын хэсгийг тайлагнах, хяналт тавих

Сум, дүүргийн Засаг дарга нь байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийн төлөвлөгөө, зарцуулалтын тайланг сум, дүүргийн ИТХ-р хэлэлцүүлэн жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагад хүргүүлнэ.

Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан төлөвлөгөө, тайланг нэгтгэн боловсруулж жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэлийн байгалийн нөхөн сэргээгдэх нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад жил бүр санхүүгийн дотоод аудит, хяналт-шинжилгээ хийнэ.

Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын мэдээ, мян.төгрөгөөр

№	Аймаг, нийслэл	2013.12.31-ний байдлаар	2014.12.31-ний байдлаар	2015.12.31-ний байдлаар	2016.12.31-ний байдлаар
1	Архангай	118 671,8	133 994,7	112 903,1	376 077,3
2	Баян-Өлгий	9 264,1	37 764,8	16 345,2	17 907,1
3	Баянхонгор	166 743,7	199 418,3	96 282,1	430 784,0
4	Булган	11 673 339,8	11 515 227,0	11 423 588,0	11 786 081,1
5	Говь-Алтай	129 881,3	76 305,2	70 701,5	299 755,0
6	Дорноговь	339 783,7	284 744,3	155 474,1	81 476,1
7	Дорнод	1 334 402,4	1 945 447,0	2 263 255,0	3 402 109,9
8	Дундговь	30 198,2	25 838,0	34 063,3	29 960,4
9	Завхан	330 274,5	151 616,9	258 435,8	180 973,5
10	Өвөрхангай	433 367,9	346 728,7	299 976,6	309 946,5
11	Өмнөговь	18 332 331,0	10 947 647,6	13 666 107,9	16 117 026,5
12	Сүхбаатар	758 898,4	539 920,1	626 620,2	711 308,7
13	Сэлэнгэ	1 384 021,2	1 490 034,3	523 119,1	611 519,8
14	Төв	1 559 272,7	2 035 959,0	1 710 831,8	1 863 310,1
15	Увс	19 885,0	28 269,8	37 081,2	29 033,3
16	Ховд	38 754,0	71 179,7	76 003,5	120 892,5
17	Хөвсгөл	23 788,1	27 178,4	37 904,0	65 721,5
18	Хэнтий	461 360,1	620 918,9	408 068,4	903 832,2
19	Дархан-Уул	340 982,5	377 073,0	397 013,5	358 215,8
20	Орхон	14 004,8	22 931,8	25 103,3	27 164,7
21	Говьсүмбэр	618 201,5	798 859,4	528 240,8	902 849,0
22	Улаанбаатар /нийслэл, дүүргүүд/	1 070 940,3	2 654 911,9	2 969 300,8	2 222 073,9
Нийт		**39 188 367,1**	**34 331 968,8**	**35 736 419,0**	**40 848 018,9**

2016 онд аймаг, нийслэлийн хэмжээнд усны нөөц ашигласны төлбөрийн орлого, орлогоос усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулсан мэдээ

№	Аймаг, нийслэл	Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн **орлого** мянган.төгрөг (ТЕГ-ын мэдээ, 2016.12.31-ний байдлаар)	Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд **зарцуулах** хувь, хэмжээ, мянган. төгрөг (БНАТ-ийн тухай хуулийн 18.1)	Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн **орлогын зарцуулалт***, мөнгөн дүнгээр, мянган. төгрөг (аймаг, нийслэлийн БОАЖГ-ын мэдээ)	Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын **зарцуулалт**, хувиар, %
1	Архангай	376,077.3	131,627.1	64,000.0	48.6
2	Баян-Өлгий	17,907.1	6,267.5	-	-
3	Баянхонгор	430,784.0	150,774.4	10,000.0	6.6
4	Булган	11,786,081.1	4,125,128.4	521,142.3	12.6
5	Говь-Алтай	299,755.0	104,914.3	40,888.4	39.0
6	Говьсүмбэр	902,849.0	315,997.2	2,587.0	0.82
7	Дархан-Уул	358,215.9	125,375.6	-	-
8	Дорноговь	81,476.1	28,516.6	16,000.0	56.1
9	Дорнод	3,402,109.9	1,190,738.5	198,623.0	16.7
10	Дундговь	29,960.4	10,486.1	5,000.0	47.7
11	Завхан	180,973.5	63,340.7	47,000.0	74.2
12	Орхон	27,164.7	9,507.6	18,000.0	-
13	Өвөрхангай	309,946.4	108,481.2	12,793.4	11.8
14	Өмнөговь	16,117,026.5	5,640,959.3	4,431,098.3	78.6
15	Сүхбаатар	711,308.7	248,958.0	55,000.0	22.1
16	Сэлэнгэ	611,519.8	214,031.9	51,669.0	24.1
17	Төв	1,863,310.1	652,158.5	295,679.5	45.3
18	Увс	29,033.3	10,161.7	-	-
19	Хөвсгөл	65,721.5	23,002.5	18,795.0	81.7
20	Ховд	120,892.5	42,312.4	6,000.0	14.2
21	Хэнтий	903,832.2	316,341.3	66,500.0	21.0
22	Нийслэл	2,222,073.9	777,725.9	25,000	3.2
НИЙТ		**40,848,018.90**	**14,296,806.6**	**5,885,776**	**41.2**

* Тайлбар: БОАЖЯ-ны НХБТГ-ын ЦТХОУХ-ийн 2017.01.23-ны №4а/434 тоотын хариуд аймаг, нийслэлийн БОАЖГ-аас ирүүлсэн Засгийн газрын 2014 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журам"-ын хэрэгжилтийн тайлангаас авав.

Анхаарах асуудал

Үндэсний аудитын газраас “Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт”-д 2016 онд нийцлийн аудитыг аймаг, нийслэлийн хэмжээнд хийсэн.

Нийцлийн аудитын тайланд:

- “зарим ус ашиглагч аж ахуйн нэгж байгууллагууд ус ашиглах дүгнэлтгүй, зөвшөөрөлгүй, гэрээ байгуулаагүйгээс ногдуулалт хийгдээгүй ..., ... Усны тухай хуулийн 28.18, 29.1, 31.1-д заасныг мөрдөхгүй байгаа ...”;
- “ус ашиглах дүгнэлт гаргуулаагүй, зөвшөөрөлгүй, гэрээ байгуулаагүй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын судалгааг гаргах, гэрээг байгуулах” гэж тусгасан байгаа тул холбогдох арга хэмжээг авч ажиллах.

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА.